

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VI ИХ НААДМЫН ЗУНЫ ТӨРЛИЙН АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН**

2018.06.20.

Арвайхээр

Зорилго.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.5, 17.1, 24.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2014 оны 27, 2015 оны 144 дүгээр зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор монголын уламжлалт үндэсний спортын төрлүүд, уламжлалт тоглоом, зан үйл, ёс заншил, соёлыг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэн сургах, хөгжүүлэх, үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/94 захирамжийн дагуу Үндэсний спортын VI их наадмын анхан шатны тэмцээнийг үндэсний бөх, үндэсний сур, шагайн харваа, ширээний шагайн төрлүүдээр зохион байгууллаа.

Үндэсний спортын VI их наадмыг 2018 оны 06 дугаар сарын 08-20-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгууллаа.

Наадмын нээлтийн үйл ажиллагааг 06 дугаар сарын 18-ны өдөр Аюушбаатарын тайлбайд зохион байгууллаа. Үндэсний спортод хувь нэмрээ оруулж байгаа болон амжилт гаргаж байгаа тамирчдыг ЗГХА-БТСГ-ын болон аймаг орон нутгийн шагналаар шагнаж урамшууллаа.

Үндэсний спортын VI их наадмын анхан шатны тэмцээнд 19 багийн 335 тамирчин оролцлоо.

Үндэсний бөхийн тэмцээнд аймгийн цолтой 13, сумын цолтой 18, залуу бөхөд 19, нийт 50 бөх барилдаж багийн дүнгээр 1-р байрыг М.Гантулга дасгалжуулагчтай Бүрд сум, 2-р байр Л.Мөнхжаргал ахлагчтай Хархорин сум, 3-р байрыг Т.Баярцэрэн ахлагчтай Хужирт сумын багууд;

Үндэсний сур харваанд эрэгтэй 36, эмэгтэй 26, нийт 62 харваач оролцож цуваа болон багийн харваанд цэц мэргэнээ сориж багийн дүнгээр 1-р байрыг С.Баяржаргал ахлагчтай Арвайхээр сум, 2-р байрыг У.Ёндон ахлагчтай Зүүнбаян-Улаан сум, 3-р байрыг М.Чойгийдавга ахлагчтай Уянга сумын багууд;

Шагайн харваанд 20 багийн 126 харваач цуваа харваа, багийн харваагаар оролцож багийн дүнгээр 1-р байрыг Т.Баярбат ахлагчтай Есөнзүйл сум, 2-р байрыг Б.Баярхүү ахлагчтай Өлзийт сум, 3-р байрыг Х.Энхбуян ахлагчтай Баян-Өндөр сумын багууд;

Ширээний шагайн морь уралдуулах, шагай шүүрэх, шагай няслах төрлүүдэд насанд хүрэгч эрэгтэй, эмэгтэй 32, өсвөрийн 29 тамирчин оролцож багийн дүнгээр 1-р байрыг Д.Нарангэрэл ахлагчтай Төгрөг сум, 2-р байрыг Л.Мөнхжаргал ахлагчтай Хархорин сум, 3-р байрыг Д.Мөнхсүлд ахлагчтай Арвайхээр сумын багууд;

Шагайн чавх харваанд 6 багийн 36 харваач оролцож Нэргүй ахлагчтай Хужирт сум, Мягмар ахлагчтай Арвайхээр сум, Ядамсүрэн ахлагчтай Хужирт сумын багууд эхний байруудыг эзэллээ.

Үндэсний спортын VI их наадмын анхан шатны тэмцээнд түрүүлсэн баг, тамирчид 08 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагдах шигшээ тэмцээнд оролцох эрхтэй боллоо.





ТОВЧ ТАЙЛАН БИЧСЭН: СПОРТЫН АЛБАНЫ ДАРГА

/Б.БАЯРМАА/